



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар A/97

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “БАЯНБУЛАГ МАНДАЛ” ХХК-ний салбар хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгаж олгосугай.

2. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50 метр газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхааран, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг иргэн (Д. Отгонбаатар)-д үүрэг болгосугай.

3. 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдөр “МАНДАЛЫН ХУРД” ХХК-д олгосон A/183 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Э.Цэрэннадмид), Цагдаагийн хэсгийн байцаагч (М.Мөнхбат, Б.Хүслэн, Б.Батбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ